



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 9 сарын 23 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Саналын хуудасны тоо, загвар батлах
нэгдсэн дугаар тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2, 59.3, 60 дугаар зүйлийн 60.1, 61 дүгээр зүйлийн 61.1, 66 дугаар зүйлийн 66.6, 66.7 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.8 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 1/6307 дугаар албан бичгээр ирүүлсэн сонгогчийн тоог үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргийн саналын хуудсыг 10 хувийн нөөцтэй байхаар тооцож 1 дүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн саналын хуудасны нэгдсэн дугаарыг 1 дүгээр хавсралтаар тогтоосугай.

3. Саналын хуудсыг батлагдсан тоо, загварын дагуу хэвлүүлж, аймаг, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлэхийг Ажлын хэсэг /Д.Даваа-Очир/-т даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР


00000243

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн
103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН
18, 28 ДУГААР ТОЙРОГТ ЯВАГДАХ НӨХӨН СОНГУУЛИЙН
САНАЛЫН ХУУДАСНЫ ТОО, НЭГДСЭН ДУГААР**

Нэгдсэн дугаар	Тойрог	Сонгогчийн тоо	Тестийн саналын хуудасны тоо	Саналын хуудасны тоо /10 хувийн нөөцтэй/
ХЭ-18	18 дугаар тойрог /Хэнтий аймаг/	51,529	752	56,682
СХД-28	28 дугаар тойрог /Сонгинохайрхан дүүрэг/	123,077	848	135,385
	Дүн	174,606	1,600	192,067
	НИЙТ			193,667



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ - 2021

САНАЛЫН ХУУДАС

18/28 дугаар тойргийн _____ р хэсэг

Хэнтий аймаг/Сонгинохайрхан дүүрэг

ХЭ-18/СХД-28



ХОЛОГРАММ НУУЦЛАЛ:
Диметалайз оруулгатай, бичиг бичвэр бүхий өндөр нууцлалтай.

НЭГДСЭН ДУГААР
МУИХСТХуулиас. 59.3 Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.

**САНАЛ ТЭМДЭГЛЭХ
ЗУУВАН УЛААН ДУГУЙ**

**Democracy Suite сонгуулийн
удирдлагын систем**

НУУЦЛАЛ

- Тусгай зориулалтын неон гэрлээр харагддаг, нүдэнд ил үл үзэгдэх UV будган нууцлал,


- МУИХСТХуулиас.59.3.Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.

- 162 гр/м2 "Cascades OCR watermark-Globe8 UV Dull" оптик гадаргуу бүхий усан хээн нууцлалтай үнэт цаас

**Democracy Suite сонгуулийн
удирдлагын систем**



**Democracy Suite сонгуулийн
удирдлагын систем**



САНАЛЫН ХУУДАС

18/28 дугаар тойргийн _____ р хэсэг

Хэнтий аймаг/Сонгинохайрхан дүүрэг

ХЭ-18/СХД-28

Та өөрийн сонгохыг хүссэн 1 нэр дэвшигчийн өмнөх зууван улаан дугуйг дүүргэн будаж саналаа тэмдэглэнэ үү. 1-ээс илүү нэр дэвшигчийн төлөө тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохыг анхаарна уу.


Нам 1	Эцэг/эхийн нэр НЭР	Нам 2	Эцэг/эхийн нэр НЭР	Нам 3	Эцэг/эхийн нэр НЭР
Нам 4	Эцэг/эхийн нэр НЭР	Нам 5	Эцэг/эхийн нэр НЭР	Нам 6	Эцэг/эхийн нэр НЭР
Нам 7	Эцэг/эхийн нэр НЭР	Нам 8	Эцэг/эхийн нэр НЭР	Нам 9	Эцэг/эхийн нэр НЭР
Бие даан нэр дэвшигч					
Эцэг/эхийн нэр НЭР					



НУУЦЛАЛ / QR код /

Саналын хуудсын нэгдсэн дугаарын мэдээллийг агуулна.

2021 оны 9 дугаар сарын 23-ний өдрийн
103 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



САНАЛ ТЭМДЭГЛЭХ ЗААВАР

МУИХСТХуулиас. 72.1 Тойрогт ногдсон мандатын тооноос илүү, эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.

НЭР ДЭВШИГЧИЙН ОВОГ, НЭР

МУИХСТХуулиас. 59.2.Саналын хуудаст нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийнх нь нэрийг том үсгээр бичих ба нам, эвслэг нэр дэвшүүлсэн бол тухайн нам, эвслийн нэрийг бичнэ.

НЭР ДЭВШҮҮЛСЭН НАМ, ЭВСЛИЙН НЭР

- МУИХСТХуулиас. 59.2.Саналын хуудаст нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийнх нь нэрийг том үсгээр бичих ба нам, эвслэг нэр дэвшүүлсэн бол тухайн нам, эвслийн нэрийг бичнэ.

- МУИХСТХуулиас. 60.1.1.намын нэрийг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар;

60.1.2.эвслийн нэрийг тухайн эвсэлд нэгдсэн орсон намуудаас хамгийн түрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын дарааллаар;

60.1.3.нам, эвслээс нэр дэвшигчийг тухайн нам, эвслээс ирүүлсэн дарааллаар;

60.1.4.бие даан нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороонд бүртгэсэн дарааллыг баримтлан нам, эвслээс нэр дэвшигчдийн нэрийн дараа.